



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО  
АЖЛЫН АЛБА

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр,  
Утас: 26-44-44, Факс: (976-11) 32-90-84  
E-mail: info@frc.mn, http://www.frc.mn

2024.02.23 № 3 / 662  
таний -ны № -т

МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН  
ХОЛБООНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ  
П.ОДГЭРЭЛ ТАНАА

Г Хамтран ажиллах тухай Г

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 265 дугаар тогтоолоор батлагдсан “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөр”-ийг үр дүнтэй хэрэгжүүлэх хүрээнд Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний зөвлөлийн дарга бөгөөд Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны А/04 дүгээр тушаалаар “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г баталсан.

Тус төлөвлөгөөний Зорилт 1.2-ын 9 дэх хэсэгт Трастын үйлчилгээ үзүүлэгчдийн эрсдэлийг үнэлэх ажлыг гүйцэтгэхээр тусгасан бөгөөд үүнд нийцүүлэн Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын тодорхойлолтод заасан трастын үйлчилгээ үзүүлэгч болон Монгол Улс дахь трастын эрх зүйн орчны талаар дэлгэрэнгүй судалгаа хийх шаардлага үүсээд байна.

Иймд Санхүүгийн зохицуулах хорооноос трастын үйлчилгээ үзүүлэгчийн суурь судалгааг хийх, холбогдох data мэдээллийг цуглуулах зөвлөх ажлын багийг сонгон шалгаруулах зарлалыг ажлын даалгаврын хамт боловсруулан хавсралтаар хүргүүлж байна.

Энэхүү судалгааг олон улсын стандарт, хууль эрх зүйн орчны өндөр мэдлэгтэй, өмнө нь судалгаа хийсэн туршлагатай хуулийн багаар гүйцэтгүүлэх хүсэлтэй байгаа тул холбогдох зарлал болоод ажлын даалгаврыг холбооны гишүүн хуулийн нөхөрлүүдэд хүргэх чиглэлд хамтран ажиллахыг хүсье.

Хавсралт. .. хуудастай.

Хүндэтгэсэн,

ДАРГА

Т.ЖАМБААЖАМЦ



# ТРАСТЫН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН СУУРЬ СУДАЛГАА ХИЙЛГЭХ МӨН МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ ТУХАЙ ЗАРЛАЛ

Огноо: 2024 оны 02 дугаар сарын 20-ний өдөр

Улаанбаатар хот

**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭР:** Трастын үйлчилгээ үзүүлэгчийн суурь судалгааг гүйцэтгэх мөн мэдээлэл цуглуулах.

Санхүүгийн зохицуулах хороо нь Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний зөвлөлийн дарга бөгөөд Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны А/04 дүгээр тушаалаар батлагдсан “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний хүрээнд трастын үйлчилгээ үзүүлэгчдийн эрсдэлийн үнэлгээг гүйцэтгэх ажил тусгагдсан тул “Трастын үйлчилгээ үзүүлэгчдийн суурь судалгаа гүйцэтгэх мөн мэдээлэл цуглуулах ажиллагаа”-г гүйцэтгэх хүсэлтэй хуулийн этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.

Мэдүүлгээр ирүүлж буй ажил гүйцэтгэгч нь хавсралтад заасан ажлын даалгаврын хүснэгтэд заасан шалгуурын дагуу тухайн ажлыг гүйцэтгэх боломжтойг нотлох баримт бичгийг ирүүлнэ.

Сонирхож буй хуулийн этгээд нь сонгон шалгаруулалтад оролцох материал, үнийн саналаа Санхүүгийн зохицуулах хороонд 2024 оны 03 дугаар сарын 08-ний өдрийн 14 цагийн дотор цахим хаяг [amlctf@frc.mn](mailto:amlctf@frc.mn)-аар болон хэвлэмлээр Санхүүгийн зохицуулах хорооны 405 дугаар тоотод ирүүлэхийг урьж байна.

**ЗАХИАЛАГЧИЙН ХАЯГ:** Санхүүгийн зохицуулах хороо, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-3, Засгийн газрын IV байр, 4 давхар 405 тоот, Утас: 261113

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО



БАТЛАВ.  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

Т.ЖАМБААЖАМЦ

ТРАСТЫН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН СУУРЬ СУДАЛГААГ ГҮЙЦЭТГЭХ МӨН  
МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

2024 оны 02 дугаар сарын 20

Улаанбаатар хот

НЭГ. ҮНДЭСЛЭЛ

1.1. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 265 дугаар тогтоолоор баталсан “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөр”-ийг үр дүнтэй хэрэгжүүлэх хүрээнд Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний зөвлөлийн дарга бөгөөд Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны А/04 дүгээр тушаалаар “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г баталсан.

Тус төлөвлөгөөний Зорилт 1.2-ын 4 дахь хэсэгт трастын үйлчилгээ үзүүлэгчдийн эрсдэлийн үнэлгээг хийж гүйцэтгэх ажил тусгагдсан. Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-аас Трастын үйлчилгээ үзүүлэгчдэд эрсдэлд сууринсан хяналтыг хэрэгжүүлэх шаардлагыг тавьдаг бөгөөд Монгол Улсын 2017 оны Харилцан үнэлгээний тайланд энэ чиглэлийн эрсдэлийн үнэлгээ хийгдэж байгаагүй талаар олон удаа дурдагдсан байдаг.

ФАТФ-аас хийгдэх ээлжит харилцан үнэлгээнд бэлтгэх хүрээнд трастын үйлчилгээ үзүүлэгчдийн эрх зүйн орчин, олон улсад үүсгэн байгуулагдсан траст Монгол Улсад үйлчилгээ явуулдаг эсэх зэрэг энэ төрлийн хуулийн этгээдтэй холбоотой мэдээллийг цуглуулж, суурь судалгааг гүйцэтгэх шаардлагатай байна.

ХОЁР. АЖЛЫН ЗОРИЛГО

Энэхүү ажил үйлчилгээ /мэдээлэл цуглуулах, судалгаа гүйцэтгэх/-ний зорилго нь Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 265 дугаар тогтоолоор баталсан “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөр”-ийн хүрээнд батлагдсан “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г үр дүнтэй хэрэгжүүлж, ФАТФ-аас хийгдэх ээлжит харилцан үнэлгээнд бэлтгэхэд оршино.

## ГУРАВ. АЖЛЫН ХАМРАХ ХҮРЭЭ

Трастын үйлчилгээ үзүүлэгчийн дата мэдээллийг цуглуулж холбогдох судалгааг гүйцэтгэнэ. Үүнд:

№	Ажлын нэр, төрөл даалгавар	Ажлын даалгавар, тавигдах шаардлага
1	<b>Даалгавар 1: Дата мэдээлэл цуглуулах</b>	Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг трастын үйлчилгээ үзүүлэгчийн талаарх холбогдох дата мэдээллийг цуглуулсан байна. Энэхүү дата мэдээллийг цуглуулахад Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын трастын тодорхойлолт, Иргэний тухай хууль, Банк бус санхүүгийн байгууллагын тухай хуулийн тодорхойлолтуудыг уялдуулж дата мэдээллийг цуглуулсан байна.
2	<b>Даалгавар 2: Суурь судалгаа гүйцэтгэх</b>	Даалгавар 1-ийн хүрээнд цуглуулсан дата мэдээлэлд үндэслэн трастын эрх зүйн орчны тухай дэлгэрэнгүй судалгааг хийж гүйцэтгэхээс гадна Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын тодорхойлолтод тусгагдсан трастын үйлчилгээг практикт байдаг эсэх, олон улсад байгуулагдсан трастын зохицуулалт зэрэг ФАТФ-ын аргачлал болон Монгол Улсын 2017 оны Харилцан үнэлгээнд тусгагдсан асуудлуудын хүрээнд дэлгэрэнгүй судалгааг гүйцэтгэсэн байна.
3	<b>Хүлээгдэж буй үр дүн</b>	Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын 40 Зөвлөмжийн хүрээнд Монгол Улс дахь трастын үйлчилгээ үзүүлэгчийн эрх зүйн орчин, ялангуяа нэр томьёоны хувьд зөрүүтэй байгаа талууд дээр нарийвчилсан судалгааг гүйцэтгэх шаардлагатай. Түүнчлэн энэ төрлийн хуулийн этгээд практикт үйл ажиллагаа явуулдаг эсэх, олон улсад үүсгэн байгуулагдсан траст Монгол Улсад үйл ажиллагаа явуулах тогтолцооны талаарх дэлгэрэнгүй судалгааны тайлан боловсруулагдсан байна.
4	<b>Хуулийн этгээдэд тавигдах шаардлага</b>	Олон улсын стандарт болон Монгол Улсын хууль эрх зүйн орчны хүрээнд судалгаа хийсэн туршлагатай байх.
5	<b>Хяналт, гүйцэтгэл</b>	Хуулийн этгээд нь Санхүүгийн зохицуулах хороотой ажил гүйцэтгэх гэрээ байгуулж ажиллах ба ажлын гүйцэтгэлээ Хяналт шалгалт, зохицуулалтыг газрын даргад тайлагнана. Ажлын гүйцэтгэлийг тооцоход дараах шаардлага тавигдана. Үүнд: <ul style="list-style-type: none"><li>- Гэрээнд заасан хугацаанд судалгааны тайланг цуглуулсан мэдээлэлд үндэслэн бэлтгэсэн байх;</li><li>- Мэдээлэл цуглуулсан эх үүсвэр нь тодорхой, баталгаатай байх;</li></ul>

		<ul style="list-style-type: none"> <li>- Гүйцэтгэсэн судалгааны тайлан нь үг хэллэг, утга зүйн хувьд чанарын шаардлага хангасан байх;</li> <li>- Гүйцэтгэсэн судалгааны хүрээнд Санхүүгийн зохицуулах хорооны холбогдох албан хаагчдад сургалт орох;</li> <li>- Гэрээнд заасан ажил хийгдэж дууссаны дараа холбогдох ажлыг бүрэн хийсэн гэж үзвэл захиалагч талд ажлаа тайлагнана;</li> <li>- Трастын үйлчилгээ үзүүлэгчдийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээг гүйцэтгэх ажлын хэсэгт судалгааны дэлгэрэнгүй үр дүнг танилцуулж, сургалт орох.</li> </ul>
<b>6</b>	<b>Хугацаа</b>	2024 оны 05 дугаар сарын 10.

### САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО